

ЭМЭГТЭЙЧҮҮД БА ЖЕНДЭРИЙН ТЭГШ ЭРХИЙН АСУУДЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

ОРШИЛ

Эмэгтэйчүүд эрт цагаас өдгөөг хүртэл эцгийн эрхт ёсноос улбаатай ялгаварлан гадуурхалтад өртөгдсөөр байна. Олон улсын гэрээ конвенцүүд батлагдсан хэдий ч асуудал байсаар байна. Эмэгтэйчүүдийг дорд үзсэн, эрхийг нь зөрчсөн нөхөн үржихүй, хөдөлмөр, боловсрол, эрүүл мэндийн чиглэлийн хууль тогтоомжийг дэлхийн улс орнууд мөрдсөөр байна. Тэгш эрхийг хангасан хууль тогтоомж улс орнуудад хэрэгжих авч мөн чанартаа эдийн засгийн үр өгөөж нь эрэгтэйчүүдэд илүү хамааралтай төдийгүй улс төрд давамгайл байр суурьтай, соёлын манлайлагч, спортын гол төлөөлөгч гэдэг дүр зураг хэвээр байна.

АЛСЫН ХАРАА

Дээрх тэгш бус байдлыг улс төрийн бодлогын хүрээнд авч үзэх нь нэн чухал юм. Даян дэлхийн ногоонтнуудын дүрэм, түүний алсын хараанд тухайлан нийгмийн шударга ёсны зарчмыг:

- „бүх хүн адил тэгш эрхтэй байх,
- улс төр, эдийн засаг, нийгэм ба соёлын ялгаварлан гадуурхалтаас ангид байх,
- хүн ёсны эрхээ эдлэх,
- нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн болон экологийн асуудлыг шийдвэрлэхэд тэгш, хүртээмжтэй оролцох боломжтой байх,
- улс төр, нийгэм, соёл, оюуны болон эдийн засгийн амьдралын бүхий л асуудлаар адил тэнцүү төлөөлөлтэй, шийдвэр гаргах түвшинд оролцоотой байх,
- боловсрол, эрүүл мэнд, бэлгийн чиг баримжаа болон нөхөн үржихүйн асуудлаар сонголт хийхэд мэдлэг мэдээллээр хангагдах эрхтэй байх,
- шийдвэр гаргах түвшний албан тушаалд эмэгтэйчүүд эрх тэгш төлөөлөлтэй байх,
- ижил төстэй ажилд ижил тэнцүү цалин хөлс олгох,
- эмэгтэйчүүдийн хувьд үнэлгээгүй төрөл бүрийн ажил, хөдөлмөр гүйцэтгэж ирснийг хүлээн зөвшөөрөх,
- шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалтыг системтэй өөгшүүлэх, дарамт шахалт, айдас, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх,
- хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хүрээнд жендэрийн асуудлыг тусгах“ гэж тусгасан байдаг.

ЗОРИЛГО

Иймийн учир ногоон намууд:

- хууль тогтоомжид суусан эцгийн эрхт ёсны улбаатай зохицуулалтуудыг халах,

- эмэгтэйчүүдийн дуу хоолой, үзэл бодлыг сонсдог нийгмийг бий болгоход улс төрд тэдний оролцоог боомилсон аливаа саад тотгорыг халах шинэчлэлийг улс төрийн үйл ажиллагаандаа өрнүүлэх,
- хүйсийн тэгш эрхийг бүрэн хангах үүднээс нийгэм, гэр бүлийн хүрээнд тогтсон эрэгтэй эмэгтэй хүмүүсийн талаарх уламжлалт хэв маягийг өөрчлөх,
- эмэгтэй, эрэгтэй хүмүүс эрх зүйн адил чадамжтай, эрх зүйн харилцаанд тэрхүү чадамжаа тэгш эдлэх боломжтой байх,
- эмэгтэйчүүд нийгэм, соёл, эдийн засаг, улс төр, экологийн асуудлаар адил тэгш эрхтэй байх боломжийг хангахын төлөө ажиллахыг зорилгоо болгоно.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Иймийн учир Ногоон намууд:

Ялгаварлан гадуурхалтын асуудлаар

- эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгахын тулд зохих хууль тогтоомжийг батлуулах зэргээр бүхий л боломжийн арга хэмжээг авах,
- эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан аливаа практик, үйл ажиллагаанаас ангид байх бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтнууд энэ талаарх үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих,
- эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхсан, хөхүүлэн дэмжсэн хүчний эсрэг иж бүрэн, өргөн хүрээний үйл ажиллагаа зохион байгуулах,
- эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хооронд тэгш байдал, шударга ёсыг дэмжих зорилгоор эдийн засгийн шинэ дүрэм, журам бий болгох,
- арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, эмэгтэйчүүдийг хүчээр түрэмгийлэх аливаа хэлбэрийг устгах,
- эхчүүдийн нийгэмд оруулж буй хувь нэмэр түүнчлэн гэр бүлдээ болон үр хүүхдээ өсгөхөд эцэг эхийн аль аль нь үүрэг хүлээх ёстой гэдгийг нийгэмд хүлээн зөвшөөрүүлэх,
- хүүхэд өсгөж, хүмүүжүүлэх нь эцэг, эх түүнчлэн нийгмийн бусад гишүүдийн хамтын үүрэг хариуцлага бөгөөд хүүхэд төрүүлдэг гэдэг үтгаар эмэгтэй хүн ялгаварлан гадуурхагдах үндэслэл болохгүй байх,
- эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хоорондын эрх тэгш байдлыг хангахын тулд одоог хүртэл уламжлал нэрийн дор оршин байгаа дарангуй шинжтэй тогтолцоог халах,

Улс төрийн эрхийн асуудлаар

- улс төр, нийгмийн амьдралд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг зогсоох,
- эмэгтэйчүүд сонгуульд оролцох, төрд алба хаших, төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрхийг баталгаажуулах,
- олон улсын хэмжээнд эх орноо эрх тэгш төлөөлөх эрхийг баталгаажуулах,
- олон нийт, улс төрийн хүрээний асуудлаарх байгууллага, холбоодын үйл ажиллагаанд эмэгтэйчүүд тэгш эрхтэй оролцохыг баталгаажуулах,

- дээд шатны албан тушаалд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго бүхий аливаа байгууллагын үйл ажиллагааг дэмжих,
- нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн зэрэг бүхий л хүрээнд эмэгтэйчүүдийн төлөөллийг хангахын тулд шаардлагатай нөхцөлд квот тогтоох аргыг хэрэгжүүлэх,

Бодлогын асуудлаар

- засгийн газрын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог баталгаажуулах,
- жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа эмэгтэйчүүдтэй бүх түвшинд өргөн хүрээнд зөвшилцөж, тус төлөвлөгөөг засгийн газрын зүгээс эн тэргүүнд хэрэгжүүлэх ажлын тоонд оруулахыг баталгаажуулах,
- улс төрийн нам, парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг тодорхой хэмжээнд хүргэх зорилт тавих,
- төрийн алба, дээд түвшний удирдлагад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг тодорхой хэмжээнд хүргэх зорилт тавих,

Боловсролын асуудлаар

- эмэгтэйчүүд, охид үнэ төлбөргүй боловсрол олж авах эрхийг баталгаажуулах,
- боловсролын салбарт эмэгтэйчүүдийг ялгаварлах явдлыг зогсоож тэгш эрхийг баталгаажуулах,
- багш, оюутан, сурагчдын дунд хүйсээр үл ялгаварлах хандлагыг түгээх зорилгод нийцсэн сургалтын хөтөлбөр, заах арга зүй, багш бэлтгэх хөтөлбөрийг боловсруулах,

Эрүүл мэндийн асуудлаар

- орон нутагт эмэгтэйчүүдийн болон бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлэх, энэ талаар бүх насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг нягт нямбай тусгах,
- жирэмслэх, хүүхэд тээх, төрүүлэх, нярайн үеийн эрүүл аюулгүй байдалд анхаарах, үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн гэрийн нөхцөлд төрөхөд туслах, эх баригчийн үйлчилгээ зэрэгт дэмжлэг авах арга замуудыг мэдээлэх,
- хүчээр үргүй болгох, хэлүү огтлох зэрэг бурангуй ёсыг хуулиар хориглох,

Гэрлэлт ба гэр бүлийн харилцааны асуудлаар

- эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил чөлөөтэй, өөрийн бүрэн хүсэл зоригийн үндсэн дээр, адил тэгш эрх эдлэн гэр бүл болох, түүнчлэн гэрлэгчид хамтын амьдралын явцад болон гэр бүл салах аль ч үед адил тэгш эрх эдэлж, үүрэг хариуцлага хүлээх зохицуулалтыг баталгаажуулах,
- гэрлэлт албан ёсны эсэхээс үл хамааран хүүхдийн асуудлаар эцэг эх адил хэмжээнд эрх эдэлж үүрэг хүлээх ба ямар ч тохиолдолд хүүхдийн эрх ашгийг эн түрүүнд харгалзана гэдгийг баталгаажуулах,

- хүүхэд асран хамгаалах, харгалзан дэмжих, өргөж авах зэрэг асуудлаар мөн адил тэгш эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэдгийг үндэсний хууль тогтоомжид тусгах, ямарч тохиолдолд хүүхдийн эрх ашгийг эн түрүүнд харгалзана гэдгийг баталгаажуулах,
- гэр бүлийн овог, ажил, мэргэжил сонгох зэрэг асуудлаар эхнэр, нөхөр адил тэгш эрх эдлэх,
- иргэний харьяаллыг олж авах, өөрчлөх, татгалзах асуудлаар эрэгтэй, эмэгтэй хүмүүс адил тэгш эрх эдлэх,

Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудлаар

- Жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгслийг чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулах,
- үр хөндөлтийг аюулгүй, хууль ёсны байх эрхийг баталгаажуулах,
- нөхөн үржихүйн боловсрол, нийтийн эрүүл ахуйн хөтөлбөр болон гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээг санхүүжүүлэх,
- үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцохгүй байх түүнчлэн жирэмслэлтийг зогсоох, үр хөндүүлэх эрхийг хуулийн хүрээнд баталгаажуулах,
- жирэмслэлтийг зогсоох эсэхт чөлөөтэй сонголт хийх боломжийг баталгаажуулах,

Хүчирхийлэл ба эмэгтэйчүүдийн аюулгүй байдлын асуудлаар

- бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллээс эмэгтэйчүүдийг хамгаалах хуулийн зохицуулалтыг сайжруулах, хүчирхийлэл, дарамт шахалтын эсрэг хуулийн хэрэгжилтийг баталгаажуулах,
- гэр бүлийн хүчирхийлэл, түүнээс сэргийлэх асуудлаар хууль тогтоомж боловсруулах,
- бэлгийн хүчирхийллийн хохирогчдын эрх ашгийг хамгаалах талаар хууль, шүүхийн байгууллагууд илүү мэдрэмжтэй ажиллах боломж бүрдүүлэх,
- жендэрийн мэдрэмжтэй байх талаар сургалт, хөтөлбөр зохион байгуулах, үүнд их дээд, ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчдыг хамруулахад онцгойлон анхаарах,
- эмэгтэйчүүдийг чадавхжуулах болон жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн харилцан уялдааг хангах,

Ажил эрхлэлтийн асуудлаар

- Хөдөлмөр эрхлэлтэд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох,
- эмэгтэй, эрэгтэй хүмүүс ижил төрлийн ажилд адил хэмжээний цалин хөлс авах зарчмыг баталгаажуулах,
- хөдөлмөрлөх эрх нь хүний салшгүй эрх болохыг баталгаажуулах,

Бэлгийн мөлжлөгийн асуудлаар

- бэлгийн мөлжлөг, хүний наймааны хохирогч ихэнхи тохиолдолд эмэгтэйчүүд байдаг тул үүнийг таслан зогсоох хууль батлах зэргээр бүхий л боломжит арга хэмжээг авах,

- биеэ үнэлэхийг хөдөлмөр эрхлэлтэд тооцохыг дэмжиж иргэний эрх зүйн зохицуулах асуудлын хүрээнд шийдвэрлэх,

Уугуул/овог аймгаар амьдардаг эмэгтэйчүүдийн асуудлаар

- уугуул, овог аймгаар амьдардаг эмэгтэйчүүдэд нийгэм, хүрээлэн буй орчин болон эдийн засгийн асуудлаар манлайлахад нь туслах, уугуул болон уугуул бус эмэгтэйчүүдийн дундах нийгэм, эдийн засгийн ялгаатай байдлыг багасгах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх,
- уугуул, овог аймгаар амьдардаг эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсрол зэрэг асуудлуудыг засгийн газрын бодлогод тусгаж баталгаажуулах, амьдрах нөхцлийг нь сайжруулахыг зорих,

Хөдөөгийн эмэгтэйчүүдийн асуудлаар

- хөдөө, орон нутагт амьдардаг эмэгтэйчүүдийн хууль ёсны эрх ашгийг баталгаажуулах,
- хөдөө, орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог хангаж, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох,

Эмэгтэйчүүдийн эерэг дүр зургийг бүтээх асуудлаар

- эмэгтэйчүүдэд хүндэтгэлтэй хандсан, хүчирхэг байдлыг нь харуулсан соёл, уламжлалыг дэмжих,
- хэвлэл мэдээлэл, сурталчилгаанд тухайлбал хувцас загвар гэх мэт салбарт эмэгтэйчүүдийн хэвийн, эрүүл бие махбодын шинж чанарыг харуулж эерэг хүндэтгэлтэй хандах явдлыг дэмжих,
- хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэйчүүдийг сөрөг дүр төрхөөр илэрхийлэх хандлагыг зогсоох талаар идэвхитэй ажиллах,
- эмэгтэйчүүдийг секс объект болгон сурталчилгаанд ашиглахын эсрэг соён гэгээрүүлэх хөтөлбөрүүдийг дэмжин хэрэгжүүлэх,

Эмэгтэйчүүд ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн асуудлаар

- хэвлэл мэдээллээр эмэгтэйчүүдийг эерэг дүр зургаар төлөөлөн харуулахад бүтээлч хандах,
- эрэгтэй эмэгтэй хүмүүсийн талаарх сөрөг хэвшмэл дүр зургийг үгүйсгэж ардчилсан нийгэмд эрх тэгш харилцаа чухал болохыг сурталчлах үйл ажиллагааг ханган ажиллана.